



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 635

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 34,120,000.00 (гучин дөрвөн сая нэг зуун хорин мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 7313 УБН улсын дугаар, JTECB01101012985 арлын дугаартай, Тоёота ландкруйзер-105 маркийн тээврийн хэрэгслийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч Завхан аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг тур орлон гүйцэтгэгч Ж.Байгалмаа, Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батмэнд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд (Завхан аймгийн Цагаанчуулут сумын засаг даргын Тамгын газар)-д эзэмшүүлэх, засаж сэлбэн ашиглах, үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т хүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ  
123006677  
32-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2023 оны ... дугаар сарын 25-ны өдрийн  
дугаар тогтоолын хавсралт

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЧУДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
ТӨРИЙН ӨМЧИЙН ДАНС БҮРТГЭЛЭС ХАСЧ, ЗАВХАН АЙМГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ  
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины марк, Зориулалт.	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн (ашиглалтад) орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын үнэ, хуригтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Суудлын автомашин TOYOTO LAND CRUISER 105	73-13 УБН	JTECB01101012985	2003/2003	186,000	34,120,000.00
	НИЙТ ДҮН					34,120,000.00 (гучин дөрвөн сая нэг зуун хорин мянган)